

## ЛАБОРАТОРИЙН ХӨНДЛӨНГИЙН ХЯНАЛТЫН АЖЛЫН ДААЛГАВАР

2019 онд замын урсгал болон их засварын 5-н багц тендер зарлагдсан бөгөөд багцын ажил эхлэхэд лабораторийн хөндлөнгийн хяналтын ажлыг дараах бүтцээр явуулна.

ТТ-ГС чиглэлийн 00-239 дахь км-н хооронд Хөндлөнгийн хяналтын баг ажиллана. Бүрэлдэхүүн нь материалын инженер 3, лаборант 3, жолооч 2 байна.

Хөндлөнгийн хяналтын багт байх шаардлагатай тоног төхөөрөмж

- Асфальтбетон хольц үйлдвэрлэх, асфальтбетон хучилт хийх ажилд стандарт, ТШ-н дагуу хийгддэг бүх туршилт шинжилгээний ажилд шаардлагатай лабораторийн тоног төхөөрөмж, багажууд
- Цементбетон ажилд стандарт, ТШ-н дагуу хийгддэг бүх туршилт шинжилгээний ажилд шаардлагатай лабораторийн тоног төхөөрөмж, багажууд
- Цементээр бэхжүүлсэн суурийн ажилд стандарт, ТШ-н дагуу хийгддэг бүх туршилт шинжилгээний ажилд шаардагдах лабораторийн иж бүрэн тоног төхөөрөмж, багажууд
- Далан суурийн ажилд стандарт ТШ-н дагуу хийгддэг бүх туршилт шинжилгээний ажилд шаардагдах лабораторийн иж бүрэн тоног төхөөрөмж, багажууд

Хөндлөнгийн хяналтын багийн гүйцэтгэх ажлууд

ТТ-ГС чиглэлийн замын 00- 239 дахь км-н хооронд зам засварын ажлын гүйцэтгэж буй бүх гүйцэтгэгч компаниудын зам засварын ажлын материалын чанарт хяналт тавьж, засварын ажилд хэрэглэх материалын туршилт, шинжилгээний ажлыг гүйцэтгэнэ.

Асфальтбетон хольц үйлдвэрлэх, асфальт бетон хучилт хийх ажилд хийх туршилт шинжилгээний ажлууд

Асфальтбетон хольцонд

Битум

- Иж бүрэн шинжилгээ хийх

Том дүүргэгч

- Элэгдлийн хэмжээ
- Ширхэглэлийн бүрэлдэхүүн
- Хувийн жин ба ус шингээлт
- Бутрагдалтын хэмжээ
- Чулууны марк
- Үзүүрлэг хавтгайн индекс
- Тоос шаварлагын агууламж
- Хүйтэн тэсвэрлэлт
- Асгаасан нягт

- Органик хольцны хэмжээ

#### Жижиг дүүргэгч

- Асгаасан нягт
- Хувийн жин ба ус шингээлт
- Ширхэглэлийн бүрэлдэхүүн
- Тоос шаварлагын агууламж
- Ширхэглэлийн модуль
- Органик хольцны хэмжээ

#### Эрдэс нунтаг

- Ширхэглэлийн бүрэлдэхүүн
- Хувийн жин
- Химийн шинжилгээ хийх

#### Завод дээр хийх туршилт

- Тогтоосон орцоор үйлдвэрт зуурч орцыг нормтой нийцэж байгаа эсэхийг шалгах
- Халуун бункерээс дээж авч ширхэглэлийг тодорхойлно.
- Халуун бункерээс дээж авч тоос шаварлагын хэмжээг тодорхойлно.
- Халуун бункерээс дээж авч битумын агууламж болон ширхэглэлийн бүрэлдэхүүнийг шалгана.
- Хольцоноос дээж авч бат бэх, нягт, уян чанарын түвшинг тодорхойлно.
- Хольцын температур хэмжинэ.

#### Талбай дээр

- Нягтруулсаны дараа хучилтаас өрөмдөж дээж авч нягтарлын хэмжээг тодорхойлох

#### Эмульс цацлага

- Эмульсийн шинжилгээ

#### Битум

- Иж бүрэн шинжилгээ хийх

Цементээр бэхжүүлсэн суурийн засварын ажлын үед хийгдэх туршилт шинжилгээний ажлууд

#### Хуучин материалаас дээж авч шинжилгээ хийх

- Чийгийг тодорхойлох
- Урсалтын хязгаар, уян налархайн хязгаар, уян налархайн индексийг тодорхойлох.
- Ширхэглэлийн бүрэлдэхүүнийг угаах аргаар тодорхойлох
- Хөрсний хуурай үеийн хамгийн их нягт, тохиромжтой чийгийг тодорхойлох
- Хөрсний ачаа даац CBR-г
- 3-н сорьц авч 7хоногийн шахалтын бат бэхийг шалгах

- Цементийн хувийг химийн аргаар тодорхойлох

Хуучин материалын цементээр бэхжүүлэх орц тогтоох

- Хуучин материал+цемент (2%,4%,6%,8%) 7 хоногийн шахалтын бат бэхээр цементийн хувийг тодорхойлох

ЦБС

7 хоногийн шахалтын бат бэх (МПа) 3.75-6.0 лаб-т

7 хоногийн шахалтын бат бэх (МПа) 2.5-4.0 талбайд

Талбай дээр

- Цементтэй хольсний дараа ширхэглэлийн бүрэлдэхүүнийг угаах аргаар тодорхойлох
- Цементний хувийг химийн аргаар тодорхойлох
- 3н сорьц авч хэвлээд 7 хоногийн шахалтын бат бэхийг үзнэ.
- Нягтруулсны дараа нягтарлыг тодорхойлно
- Чийгийг газар дээр нь хурдавчилсан аргаар тодорхойлно

Суурийн доод үеийн засварын ажлын үед хийгдэх туршилт шинжилгээний ажлууд

- Суурийн доод үеэс дээж авч үндсэн үзүүлэлтүүдийг тодорхойлно
- Чийгийг тодорхойлох
- Урсгалтын хязгаар, уян налархайн хязгаар, уян налархайн индексийг тодорхойлох.
- Ширхэглэлийн бүрэлдэхүүнийг угаах аргаар тодорхойлох
- Хөрсний хуурай үеийн хамгийн их нягт, тохиромжтой чийгийг тодорхойлох
- Хөрсний ачаа даац CBR-р тодорхойлох

Үндсэн цементээр бэхжүүлж орцыг тодорхойлох

- Цементийн хувийг 2%,4%,6%,8%-р хийж сорь бэлтгэн 7 хоногийн шахалтын бат бэхийг туршина.

Суурийн доод үе ( прокторын хэв)

7 хоногийн шахалтын бат бэх (МПа) 1.5-3.0 лаб-т

7 хоногийн шахалтын бат бэх (МПа) 1.0-2.0 талбайд

Талбай дээрх туршилт

- Цементтэй хольсний дараа ширхэглэлийн бүрэлдэхүүнийг угаах аргаар тодорхойлох
- Цементний хувийг химийн аргаар тодорхойлох
- 3н сорьц авч хэвлээд 7 хоногийн шахалтын бат бэхийг үзнэ.
- Нягтруулсны дараа нягтарлыг тодорхойлно
- Чийгийг газар дээр нь хурдавчилсан аргаар тодорхойлно

Хөвөө, түр зогсоол амрах талбайн засварын ажилд хийгдэх туршилт шинжилгээний ажлууд

- Карьераас дээж авч үндсэн үзүүлэлтүүдийг тодорхойлно
- Чийгийг тодорхойлох
- Урсалтын хязгаар, уян налархайн хязгаар, уян налархайн индексг тодорхойлох.
- Ширхэглэлийн бүрэлдэхүүнийг угаах аргаар тодорхойлох
- Хөрсний хуурай үеийн хамгийн их нягт, тохиромжтой чийгийг тодорхойлох
- Хөрсний ачаа даац CBR-р тодорхойлох

Талбай дээр хийгдэх шинжилгээ

- Нягтруулсны дараа нягтыг тодорхойлох
- Чийгийг газар дээр нь хурдавчилсан аргаар тодорхойлно.